

ҮАГ

**Зам тээвэр, аялал жуулчлалын яамны
төсвийн хөрөнгийн зарцуулалт,
үр дүн**

**Төсвийн хөрөнгийн
зарцуулалтад тавих дотоодын
хяналт хангалтгүй байна.**


Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын хүсэлтийн дагуу хийсэн аудитын тайлан

Улаанбаатар хот 2006 оны 9 дүгээр сар

Агуулга

Тайланг бэлтгэсэн: <i>Нэгдүгээр газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Ганбилэг</i> <i>Аудитын менежер Ж. Батсайхан</i> <i>Ахлах аудитор Л. Одгэрэл</i> <i>Шинжээч Ц. Эрдэнэчулуун Ж. Сарантуяа</i>	Товчилсон үгсийн жагсаалт 3
2006 оны 6 дугаар сар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Уг тайланг УАГ-ын вэб сайт-аас үзнэ үү: <u>www.mnao.pmis.gov.mn</u>	Бүлэг 1 ЗТАЖЯ төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулсан боловч төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<ul style="list-style-type: none">• ЗТАЖС-ын төсвийн орлого нэмэгдсэн байна 5• ЗТАЖЯ-ны батлагдсан төсөв хэмнэгджээ. 7• ЗТАЖЯ нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй хураангуй бүртгэлийг бүрэн хөтлөөгүй байна 8
ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>	Бүлэг 2 АЖС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг зохих журмын дагуу хийгээгүй байна
	<ul style="list-style-type: none">• АЖС-ийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна 7• АЖС-ийн хөрөнгийг зохих журмын дагуу үр ашигтай зарцуулж чадаагүй байна. 11• АЖС-ийн хөрөнгийг зохих журмын дагуу үр ашигтай зарцуулж чадаагүй байна. 12
	Бүлэг 3 Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналт хангалтгүй байна. 15

Агуулга

	• Замын сангийн төлөвлөгөөт орлого бүрэн төвлөрсөн байна	15
	• Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна	17
	• ЗТАЖЯ-ны Тээвэр үйлчилгээний төвийн барилгын талаар	22

Товчилсон үгсийн жагсаалт

АЖС	Аялал жуулчлалын сан
АЗХСТ	Авто замын хяналт судалгааны төв
ЗГҮААЭГ	Засгийн газрын Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
СЭЗС	Санхүү, эдийн засгийн сайд /хуучин нэрээр/
СЯ	Сангийн яам
ЗТАЖС	Зам тээвэр, аялал жуулчлалын сайд
УБТЗХНН	Улаанбаатар Төмөр замын Хувь нийлүүлсэн нийгэмлэг
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Зам тээвэр аялал жуулчлалын сайдын хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн дагуу ЗТАЖЯ-ны 2005 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Энэхүү аудитын зорилт нь ЗТАЖЯ-ны 2005 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, тэдгээрийг цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөхөд чиглэгдсэн болно.

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан хийлээ. Үүнд:

- Сангийн яамнаас ЗТАЖЯ-ны 2005 оны төсвийг хэрхэн төлөвлөж, хуваарилсан талаар судалгаа, тодруулга авах,
- ЗТАЖЯ-ны 2005 оны төсвийн хөрөнгийн гүйцэтгэл, түүнийг тайлагнасан байдлыг түүвэрчлэн шалгах,
- Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлын ЗТАЖЯ-д батлагдсан хөрөнгийг гүйцэтгэлтэй нь харьцуулан дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгах,
- Тусгай сангуудын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгахтай холбоотойгоор яамны харъяа зарим байгууллагад түүвэрчилсэн шалгалт хийх,
- Шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, хүмүүсээс тайлбар, нотолгоо авах, ярилцлага хийх, мөрдөгдөж буй журам зааврын талаар санал асуулга авах,

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

ЗТАЖЯ төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулсан боловч төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна



Танилцуулга

Монгол Улсын Их Хурлаар 2004 оны 9 дүгээр сарын 22-нд батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай хуулиар Зам тээвэр, аялал жуулчлалын яам байгуулагджээ. Засгийн газрын 2004 оны 201 дүгээр тогтоолоор ЗТАЖЯ-ны зохион байгуулалтын бүтцийг баталсан байна.

А. ЗТАЖСайдын төсвийн орлого нэмэгдсэн байна

ЗТАЖСайдын 2005 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	2004 оны гүйцэтгэл	2005 оны		2004 оноос	Зөрүү Төлөвлөгөөнөөс
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Орлого бүгд	14,295.40	15,419.00	16,321.46	2,026.06	902.46
	навигацийн орлого	13,435.00	14,500.00	14,500.00	1,065.00	0.00
	түрээсийн орлого	326.60	384.00	388.93	62.33	4.93
	ногдол ашиг	533.80	535.00	809.11	275.31	274.11
	замын төлбөрийн хураамж	307.90		307.90	307.90	307.90
	аялал жуулчлалын хураамж	315.52		315.52	315.52	315.52

Монгол Улсын 2005 оны төсвийн тухай хуулиар ЗТАЖС-ын төсвийн багцын орлого 15,419,0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 16,321,5 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 902,5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын төлөвлөгөөг зүйл тус бүрээр нь авч үзвэл 14,500,0 сая төгрөгийг навигацийн орлогоор, 384,0 сая төгрөгийг түрээсийн орлогоор, 535,0 сая төгрөгийг ногдол ашгийн орлогоор тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн орлогын төлөвлөгөөний 2005 оны гүйцэтгэлийг 2004 оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд орлого өмнөх оноос 2,026,1 сая төгрөг буюу 114 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх орлогыг нэр төрлөөр нь задалж үзвэл навигацийн орлогыг 1,065,0 сая төгрөгөөр, түрээсийн орлогыг 62,3 сая төгрөгөөр, ногдол ашгийн орлогыг 275,3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Сангийн сайд, ЗТАЖС-ын хамтарсан 2005 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 272/160 дугаар тушаалаар олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн зам ашигласны төлбөрийн орлогын 307,9 сая, АЖС байгуулсантай холбогдуулан Дэд бүтцийн сайдын 2004 оны 40 дүгээр тушаалаар “Чингис хаан” Олон Улсын буудлаар үйлчлүүлсэн зорчигчдын хураамжийн орлого (нислэгийн такс)-ын 8 хувьтай тэнцэх 315,5 сая төгрөгийг тус тус өөрийн орлогын 2005 оны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

ЗТАЖС-ын 2005 оны төсвийн багцын төсөвт зардлын гүйцэтгэл

/сая.төг/

Зардлын ангилал	2004 оны гүйцэтгэл	2005 оны		Зөрүү	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хэтрэлт
I. Нийт зардлын дүн	40,047.60	46,246.90	33,790.40	12,456.50	
1.1 Урсгал зардлын дүн	79,1	430.2	1,148.10		717.9
Бараа үйлчилгээний зардал	40,0	348.2	1,075.40		727.2
Татаас ба урсгал шилжүүлэг	38,7	82	72.7	-9.3	

ЗТАЖЯ- ны 2005 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

1.2 Хөрөнгийн зардал	38,968.50	45,816.70	32,642.20	-13,174.50	
а. Дотоод хөрөнгө оруулалт	17,792.20	22,094.60	21,694.40	-400.2	
Төсвийн хөрөнгө оруулалт	11,499.73	13,794.60	13,856.50		61.9
Замын сангийн хөрөнгө оруулалт	6,292.43	8,300.00	7,837.90	-462.1	
б. Гадаадын зээлээс	22,176.40	23,722.10	10,947.80	-12,774.30	
II. Зардлын эх үүсвэр	40,047.60	46,246.90	33,790.40	-12,456.50	
Төсвөөс	11,578.88	14,224.80	14,238.50		13.7
Авто замын сангаас	6,292.43	8,300.00	7,837.90	-462.1	
Гадаадын зээлээс	22,176.40	23,722.10	10,947.90	-12,774.20	
Өөрийн орлогоос			766.1		766.1

Дээрх хүснэгтээс үзэхэд 2005 оны төсөвт зардлын гүйцэтгэлийг 2004 оны гүйцэтгэлтэй зэрэгцүүлж үзэхэд нийт зардал 6,2 сая төгрөгөөр буурсан байна.

ЗТАЖС-ын 2005 оны төсвийн багцын урсгал зардлын гүйцэтгэл өнгөрсөн оны гүйцэтгэлээс 1069,0 сая төгрөгөөр өссөн байна.

ЗТАЖСайдын төсвийн багцын нийт зардал 46,246,9 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 33,790,4 сая төгрөг зарцуулан, батлагдсан төсвийг нийт дүнгээрээ 12,456,5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Харин төсвийн урсгал зардал батлагдсан төсвөөс 717,9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Б. ЗТАЖЯ-ны батлагдсан төсөв хэмнэгджээ.

ЗТАЖЯ-ны 2005 оны урсгал зардалд 430,3 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 364,7 сая төгрөг зарцуулан, батлагдсан төсвийг 65,6 сая төгрөгөөр хэмнэжээ.

ЗТАЖЯ-ны цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 138,4 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 110,4 сая төгрөг зарцуулжээ.

2005 онд яамны бараа, үйлчилгээний зардалд 255,3 сая төгрөг батлагдсаны 43 хувь буюу 108,6 сая төгрөг нь нийтлэг чанартай зардалд, 57 хувь буюу 146,7 сая төгрөг нь тусгай материал үйлчилгээний зардалд тус тус хуваарилагдсан байна.

Гүйцэтгэлээр бараа үйлчилгээний зардал нийт дүнгээрээ 227,9 сая төгрөг зарцуулснаас 44 хувь буюу 100,1 сая төгрөг нь нийтлэг чанартай зардалд, 10 хувь буюу 127,8 сая төгрөг нь тусгай материал үйлчилгээний зардалд зарцуулан бараа үйлчилгээний зардлыг 27,4 сая төгрөгөөр хэмнэжээ.

2005 онд төсвийн хөрөнгөөр 6,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 4,3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 0,2 сая төгрөгийн ном худалдан авч 4,9 сая төгрөгийн хөрөнгийг Иргэний Нисэхийн Ерөнхий газраас хандивласан байна.

В. ЗТАЖЯ-ны нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийг бүрэн хөтлөөгүй байна

ЗТАЖЯ-ны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын явцад дараах зөрчил илэрлээ.

ЗТАЖЯ-ны ажилтнуудын санаачилгаар Төрийн нарийн бичгийн даргын 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тушаал гарч “Цунамид” нэрвэгдсэн орнуудын иргэдэд тусламж үзүүлэхээр 2 өдрийн үндсэн цалинтай тэнцэх хөрөнгийг хандивлахаар шийдвэрлэсэн боловч цалингаас суутгаж аваагүй байна.

Харин дээрх шийдвэрийн дагуу 2005 онд 500,000 төгрөгийг НҮБ-ын хүүхдийн хөгжлийн санд хандивлаж, урсгал зардалд тооцсон байна. Иймд энэ хөрөнгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичлээ.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2005 оны 122 дугаар захирамжийг үндэслэж, СЭЗС-ын баталсан төсвөөр Хархорин хот байгуулагдсаны 785 жилийн ойд зориулж 6,9 сая төгрөгийг Аялал жуулчлалын газраас томилогдсон ажлын хэсэг ЗТАЖЯ-ны урсгал төсвөөс урьдчилан бэлнээр гаргуулан тухайн арга хэмжээнд зарцуулсан боловч 1,7 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

Дээрх зөрчил дутагдлыг арилгуулахаар албан шаардлага өгөв.

Дээрх хөрөнгийг Монгол Улсад тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан баригдаж байгаа “Чингис хаан” цогцолборын барилгын ажлын хөрөнгөд зориулж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЗГҮААЭГазарт олгосон хөрөнгөөс нөхөн гаргаж ЗТАЖЯ-ны харилцах дансанд 2005 оны 12 дугаар сарын 28-нд шилжүүлсэн боловч 360,000 төгрөгийг дутуу шилжүүлсэн тул төлбөрийн акт бичсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2005 оны 1 дүгээр сарын 18-нд 885 дугаар төлбөрийн даалгавраар ЗТАЖЯ-ны студийн тоног төхөөрөмжийн үнэнд 14,794,8 мянган төгрөгийг “Протех” ХХК-д шилжүүлсэн боловч уг хөрөнгө яамны хөрөнгийн дансанд бүртгэгдээгүй, харин Иргэний нисэхийн ерөнхий газрын хөрөнгөнд бүртгэлтэй байна.

Яамны төсвөөс 2005 онд улс орныг гадаадад сурталчлах чиглэлээр 50,0 сая төгрөг батлуулан зарцуулсан боловч батлагдсан төсөв, гүйцэтгэлийн тайлангийн холбогдох баримтыг хариуцагч О. Бат-Эрдэнэ, хөдөлмөрийн чадвараа түр алдсанаас шалтгаалан аудитын явцад гаргаж өгөөгүй болно.

Дээрх хөрөнгөөс 8 нэрийн гарын авлага, сэтгүүл, танилцуулга хуудас, календарчилсан танилцуулга зэрэг 21,9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендер зарлаагүйн гадна нягтлан бодох бүртгэлд тусгалгүй шууд зардалд бичсэн байна. Иймд энэ зөрчлийг арилгах талаар албан шардлага өгөв.

Япон Улсын “ЈАТА” аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд 11,2 сая төгрөгийг, гарын авлага, сэтгүүл, танилцуулах хуудас, телевизийн нэвтрүүлэг,

хүлээн авалт, уулзалт, календарчилсан танилцуулга, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа зэрэгт 38,8 сая төгрөг зарцуулжээ.

Дээрх хөрөнгө нь АЖС-ийн хөрөнгөөс санхүүжигдэх зардал боловч яамны төсвийн зардалд төлөвлөж зарцуулсан нь “Аялал жуулчлалын тухай” хуулийн 19,1-д “ Дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах, жуулчлалаас байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгах, түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах, байгаль, түүх, соёлын өвийг дэмжих, хамгаалахад шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор аялал жуулчлалын сан байгуулна” , 19,2-д “Аялал жуулчлалын сан нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

ЗТАЖЯ-ны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэлд дараахь зөвлөмж өгч байна.

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан мөрдүүлж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах
- Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах
- Аялал жуулчлалын сангаас гарах зардлыг яамны урсгал төсвөөс гаргахгүй байх талаар анхаарч ажиллах

Бүлэг 2

АЖС-ийн хөрөнгийн
бүрдүүлэлт, зарцуулалтыг
зохиж журмын дагуу
хийгээгүй байна



Танилцуулга

“Аялал жуулчлалын тухай” хуулийн 19.1, 19.2 –д зааснаар дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах, жуулчлалаас байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгах, байгаль, түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах, байгаль, түүх, соёлын өвийг дэмжих, хамгаалахад шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор аялал жуулчлалын санг байгуулан ажиллаж байна.

Аялал жуулчлалын сан нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дараахь эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнд:

- Тухайн жилд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
- Гадаад, дотоодын иргэд, байгууллагын тусламж, хандив
- Хуулиар хориглоогүй бусад эх, үүсвэр зэрэг болно.

АЖС-ийн төвлөрүүлэн захирагч Аялал жуулчлалын газрын дарга бөгөөд “Аялал жуулчлалын санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, үр ашгийг дээшлүүлэх, сангийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусгуулах, гүйцэтгэлийг зохион байгуулж, Засгийн газрын өмнө хариуцах зэрэг эрх үүрэг хүлээж байна.

А. Аялал жуулчлалын сангийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна

Аялал жуулчлалын сангийн орлого 2005 онд дараахь байдалтай төвлөрсөн байна. Үүнд:

Аялал жуулчлалын сангийн 2005 оны орлогын төвлөрүүлэлт

сая .төгрөгөөр

Орлогын төрөл	2005 оны		Зөрүү
	Төвлөгөө	Гүйцэтгэл	
Олон улсын зорчигчдын хураамжийн орлогын 8%	208,663.33	201,714.83	-6,949.0
2004 оны 11-12 сарын 8%	27,829.60	27,829.60	0
Хандив	60,000.00	60,000.00	0
Бусад орлого	987.50	987.50	0
Данс андуурсан орлого	0	63,900.00	63,900,0

Дэд бүтцийн сайдын 2004 оны 40 дүгээр тушаалаар “Чингэс хаан” олон улсын нисэх буудлаар үйлчлүүлсэн зорчигчдын хураамжийн орлого (нислэгийн такс)-ын 8 хувьтай тэнцэх хөрөнгийг Аялал жуулчлалын санд төвлөрүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газарт даалгажээ.

Олон улсын зорчигчдын хураамжийн орлого 2005 онд төлөвлөсөн хэмжээнээс 6,9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Энэ нь АЖС-ийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна. Тухайлбал дээрх орлогын эх үүсвэрийг Иргэний нисэхийн ерөнхий газраас бүрэн нэхэмжилж нягтлан бодох бүртгэлд авлагаар тусгаагүй байна.

УБТЗХНН-ээс 60,0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрүүлэхээс 123,6 сая төгрөгийн хандив төвлөрчээ.

Энэ нь УБТЗХНН-ээс 2005 оны 5 дугаар сарын 6-ны өдөр 63,9 сая төгрөг АЖС-ийн дансанд данс андуурч орж ирсэнтэй холбоотой байна.

Дээрх мөнгийг УБТЗХНН-ийн даргын 2005 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 15/641 дугаар албан бичгийн дагуу АЖС-ийн данснаас 2005 оны 7 дугаар сарын 27-ны өдөр 134 дугаар шилжүүлгээр Төрийн сангийн 900080001 дансаар дамжуулан 53562,44 ам.долларт хөрвүүлэн “Santoku enterprise” компанид шилжүүлжээ.

Дээрх албан бичигт “Тус байгууллагын Японы “Santoku enterprise” компанитай хийсэн гэрээний дагуу “EXPO-2005” олон улсын үзэсгэлэнд нэгдсэн журмаар оролцох сурталчилгааны зардалд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд энэхүү зардлыг “Santoku enterprise” компанид нэхэмжлэлийн дагуу шилжүүлж өгнө үү” гэсэн хүсэлт тавьжээ.

АЖС-ийн бусад орлого хэмээн тооцож бүртгэсэн 987,5 мянган төгрөг нь аялал жуулчлалын байгууллагад гэрчилгээ худалдсанаас орсон орлого байна.

Энэхүү гэрчилгээг нэг бүрийг 12,5 мянган төгрөгөөр худалддаг бөгөөд энэ талаар ямар нэг хууль, эрх зүйн зохицуулалт хийгдээгүй байна.

Б. Аялал жуулчлалын санг зохих журмын дагуу үр ашигтай зарцуулж чадаагүй байна.

ЗТАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга АЖС-аас 2005 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг зардлын зүйл тус бүрээр баталсан боловч сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тус бүрийг нарийвчлан төлөвлөөгүй байна.

АЖС-ийн 2005 оны төсөвт зардлын гүйцэтгэл

Зардлын төрөл	2005 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Томилолт	56.6	56.6	0
Гадаад, дотоод сурталчилгаа	91.8	91.8	0
Худалдан авалт	107.3	107.3	0
Бусад /гэрчилгээ/	1.2	1.2	0
	63.9	63.9	0
	320.8	320.8	0

ЗТАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаал болон бусад шийдвэрийн дагуу Монгол Улсыг гадаадад сурталчлах зорилгоор гадаадад зохиогдсон арга хэмжээнүүдийн томилолтын зардалд нийт 56,6 сая төгрөг зарцуулсан боловч зардлын гүйцэтгэлийн тайлан, баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байна.

Тухайлбал, АЖС-ийн харилцах данснаас 2005 онд томилолтын зардалд 22.2 сая төгрөгийг яамны мэргэжилтэн Б.Халиун бэлнээр авч томилолтоор явах хүмүүст тараан өгсөн байна.

Энэ мөнгийг анхан шатны баримтыг дутуу бүрдүүлэн холбогдох хүмүүстэй тооцоо нийлээгүйн гадна кассын тайлан гаргалгүй харилцахаас гарсан дүнгээр шууд зардалд бичсэн байна.

АЖС-ийн харилцах данснаас их хэмжээний бэлэн мөнгийг энэ ажлыг хариуцдаггүй хүн авч зарцуулсан нь албан ёсоор томилогдсон кассын нярав байхгүйтэй холбоотой байна.

Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, ЗТАЖС Г.Батхүү, яамны газрын дарга А.Ганбаатар, ММ агентлагийн сурвалжлагч Д.Батзаяа нарын 2005 оны 6 дугаар сарын 9-16-ны өдрүүдэд Бельги, Нидерланд, Герман улсуудад хийх айлчлалын гадаад томилолтын зардалд нийт 12,9 сая төгрөг төлөвлөгдөж, АЖС-аас 7,0 сая, үлдсэн мөнгийг яамны урсгал төсвөөс гаргасан байна.

Д.Батзаяагийн гадаад томилолтын зардалд 2,4 сая төгрөг төсөвлөгдсөнөөс 2,1 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Дээрх мөнгөний зарцуулалтын баримт материалтай танилцахад зочид буудлын төлбөрт 800 евро буюу 1,2 сая төгрөг зарцуулсан гэх боловч зочид буудлын баримт нь Д. Гомбо гэдэг хүний нэр дээр байгаа хуурамч баримт хавсаргасан байна.

АЖС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй байна. Тухайлбал: Жуулчны бүртгэлийн программ, сурталчилгааны сэтгүүл, ном, календарь, CD, DVD болон кино худалдан авахад нийт 48,2 сая төгрөг зарцуулсан боловч тендер шалгаруулалт зарлаагүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь нийлүүлэгчийн өрсөлдөөнийг хязгаарлаж, төсвийн хэмнэлт гаргах боломжийг алдаж, ашиг сонирхлын зөрчлийг бий болгох эрсдлийг нэмэгдүүлж байна.

Худалдан авсан зарим бараа, ажил үйлчилгээг нягтлан бодох бүртгэлд тусгаж, орлого, зарлагын тайлан гаргаагүй байна. Тухайлбал, 2005 онд АЖС, урсгал төсвийн хөрөнгөөр аялал жуулчлалын холбогдолтой худалдан авсан 34,2 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна.

Бүртгэлд тусгагдаагүй бараа материал

д/д	Худалдан авсан бараа бүтээгдэхүүн	Тоо	Үлдэгдэл Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	DVD /3 төрөл/	2,584	4,500.00	11,628,000
2	CD Land of legend	1,581	4,000.00	6,324,000
3	Tourist map	10,294	1,434.00	14,761,596
6	UB Guide сэтгүүл	51	1,000.00	51,000
8	800 жилийн ойн том хуанли	33	2700	89,100
10	Статистикийн эмхэтгэл	338	2375	802,750
11	Хөтөч тайлбарлагчдын гарын авлага	200	2500	500,000
	Нийт			34,156,446

Сангийн хөрөнгөөр урьдчилан төлөвлөөгүй, ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материал худалдан авч үр ашиггүй зардал гаргажээ.

Сангийн хөрөнгөөр Аялал жуулчлалын бүртгэлийн программыг 600,0 мянган төгрөгөөр захиалж хийлгэсэн боловч ашиглалтгүй байна.

2005 онд сангаас гарах ёстой 50,0 сая төгрөгийг яамны урсгал төсвөөс санхүүжүүлсэн байна. Энэ нь АЖС-ийн орлогыг дутуу бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Зөвлөмж :

АЖС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн ЗТАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ц. Бат-Энхэд дараахь зөвлөмж өгч байна.

- АЖС-ийн зориулалтыг нарийвчлан тодорхойлж баталгаажуулах
- АЖС-аас зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөл арга, хэмжээ тус бүрээр баталгаажуулж мөрдөх
- АЖС-ийн бүрдүүлэлт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтын тогтолцоог холбогдох хууль, тогтоомжийн дагуу оновчтой зохион байгуулж, баталгаажуулах

Бүлэг 3

Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналт хангалтгүй байна.

А. Замын сангийн төлөвлөгөөт орлого бүрэн төвлөрсөн байна.

“Замын тухай” хуулийн 19 дүгээр зүйлд Улсын авто замын сангийн эх үүсвэр нь:

- Авто бензин, дизелийн түлшний албан татвар
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- Авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авах

төлбөр

- Энэ хуулийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль
- Зээл, тусламж, хандивын орлого
- Улсын төсвөөс олгосон хөрөнгө
- Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын авто тээврийн хэрэгслээс авах хураамжаас бүрдэнэ гэж заажээ.

Замын сангийн хөрөнгийн зарцуулалтыг түүвэрчилсэн байдлаар шалгалаа.

“Монгол Улсын 2005 оны төсвийн тухай” хуулийн дагуу ЗТАЖЯ-ны 2005 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 22094,6 сая төгрөг батлагдсан байна.

Засгийн газрын 2005 оны 21 дүгээр тогтоолоор дээрх хөрөнгийг улсын төсвөөс 13794,6 сая, замын сангаас 8300,0 сая төгрөг санхүүжүүлэхээр хуваарилсан байна.

Гүйцэтгэлээр 21911.7 сая төгрөгийн санхүүжилт хийж, батлагдсан төсвөөс 182,9 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

СЯ-наас 2005 онд ЗТАЖЯ-ны улсын төсвийн харилцах дансанд 13856,5 сая, замын сангийн харилцах дансанд 8055,2 сая, нийт 21911,7 сая төгрөг санхүүжүүлсэн байна.

2005 оны эцэст ЗТАЖЯ –ны улсын төсвийн хөрөнгө оруулалтын харилцах данс 2,9 тэрбум, замын сангийн харилцах данс 2,5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сангийн сайдын 2005 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 4-9а /4126 дугаар тушаалаар санхүүжилтийн материалыг 12 дугаар сарын 15-ны дотор авч, санхүүжилтийг 12 дугаар сарын 25-наас хойш хийхгүй байхаар шийдвэрлэснийг ЗТАЖЯ хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал, ЗТАЖЯ 2005 оны 12 дугаар сарын 28-ны өдөр гүйцэтгэлээ ирүүлж Сангийн яам 12 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд 7225,8 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн байна. ЗТАЖЯ 3734,8 сая төгрөгийн зохицуулалт хийсний 58 хувийг 12 дугаар сарын 29-ний өдөр, үлдэх хэсгийг 2006 онд санхүүжүүлсэн байна.

СЯ-наас ЗТАЖЯ-нд Эрдэнэсант- Улаанбаатар чиглэлийн замын шинэчлэлтэд 70,0 сая, Хархорин Хужиртын зам хайгуулын ажилд 125,0 сая, Номгон хайрхан ХХК-д замын сүлжээний засвар арчлалтад 98,2 сая, нийт 293,2 сая төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгосон байна.

Гэтэл ЗТАЖЯ тухайн үед уг мөнгийг буцаан төсөвт буцааж төвлөрүүлээгүй байсныг СЯ 2006 оны 3 дугаар сарын 3-нд буцаан татаж авчээ.

СЯ Орхон аймгийн гэр хорооллын дундах 3,5 км замын ажлын гүйцэтгэл гараагүй байхад 2005 оны 10 дугаар сарын 18-нд 120,0 сая төгрөгөөр санхүүжүүлжээ. Гэтэл 2005 оны 12 дугаар сарын 29-нд гүйцэтгэл 59,1 сая төгрөг гарч өмнөх санхүүжилтийг тооцолгүйгээр дахин 59,1 сая төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь “Замын тухай” хуулийн 18.4-д “ Улсын авто замын санг олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, тохижуулах, замын үйлдвэрлэлийн баазыг хөгжүүлэх, мэргэжлийн хяналт тавихтай холбогдон гарах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэсэн заалтыг зөрчжээ. ЗТАЖЯ 120,0 сая төгрөгийг “Булган АЗЗАН”-д өгөхгүйгээр дансандаа байлгаж байгаа боловч улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

ЗТАЖЯ Эрдэнэсант-Лүн чиглэлийн замын шинэчлэлтэд 13,3 сая, Хархорин-Хөшөө цайдмын хатуу хучилттай замд 25,8 сая, Эрдэнэсант-Арвайхээр чиглэлийн замд 7,2 сая, Дэлхийн банкны Тээвэр хяналтын төвийн дотоод эх үүсвэрт 4,0 сая, Дархан-Эрдэнэтийн зам засварт 8,9 сая, Баруун Урт-Өндөрхааны зам засварт 19,4 сая, нийт 78,6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчдэд олгоогүй байна.

Авто замын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийг үндэслэн Засгийн газрын 2002 оны 177 дугаар тогтоолоор олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам, төлбөрийн хэмжээг батлан 2004 оноос хэрэгжүүлснээс 2005 онд 279,3 сая төгрөгийн орлого орсон байна.

2005 оны эцэст санхүүгийн тайланд тусгагдсан 14,9 тэрбумтөгрөгийн өглөг, 3,5 тэрбум төгрөгийн авлагыг актаар баталгаажуулаагүй байна.

Авто замын төлбөрийн орлогыг сайдын төсвийн багцын 2005 оны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

ЗТАЖС-ын 2005 оны 24 дүгээр тушаалд “Олон улсын болон улсын чанартай авто замын тодорхой хэсгийн засвар арчлалт болон ачаа, зорчигч тээвэрлэлтэд хяналт тавьж зохицуулалт хийх, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллах Автозам, тээврийн хяналт зохицуулалтын албад, зам ашигласны төлбөрийн хураамж авах цэгүүдийг байгуулж байршлыг нь тодорхойлон төлбөрт үйлчилгээний цэгүүдийн зардлыг авто зам ашигласны төлбөр, үйлчилгээний орлогоос санхүүжүүлэх” -ээр заасны дагуу 2005 онд 11 авто зам, тээврийн хяналт зохицуулалтын алба, 23 Төлбөр хураах цэгийг байгуулан Төлбөр хураах цэгүүдийн орлогыг 489,1 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 279,3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төлбөр хураах цэгийн орлого хураалтын байдалтай танилцахад авто замаар зорчигч тээврийн хэрэгсэл тус бүрээс төлбөрийг авч чадахгүй байгаа нь ажиглагдлаа. Тухайн цэгт нэг ээлжинд 2 төлбөр хураагч ажилладаг бөгөөд хураасан орлогоо Төлбөр хураах цэгийн менежерт өгч банкинд тушаалган менежер харьяа Авто зам засварын ангитай үнэт цаасны тооцоог хийдэг байна. Авто зам засварын ангиас гэнэтийн шалгалт, тооллого хийдэг боловч төлбөрийг хувьдаа ашигласан зөрчил гарч байсан байна. Тухайлбал, Налайх-Тэрэлжийн чиглэлийн авто замын Төлбөр хураах цэгийн менежер Ганбат 2,1 сая төгрөгийн орлогыг хувьдаа завшсан байна.



Б. Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Засгийн газрын 2005 оны 21 дүгээр тогтоолд зам, гүүрийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээнд төсвөөс 13794,6 сая, замын сангаас 2300,0 сая, замын

засвар, арчлалтад замын сангаас 6,0 тэрбум, нийт 22094,6 сая төгрөг зарцуулахаар заажээ.

Сангийн сайд, ЗТАЖСайдын 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 336/195 , 2005 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 367/205 дугаар тушаалаар батлагдсан дүнд багтаан замын барилгын 11 ажлыг 12 ажлаар, замын засвар, арчлалтын 21 ажлыг 24 ажлаар солих зохицуулалт хийжээ.

2005 онд ЗТАЖЯ-ны улсын төсвийн харилцах данснаас замын их барилгын ажилд 14061,8 сая, замын сангийн харилцах данснаас замын засвар, арчлалтад 6210,8 сая төгрөг зарцуулжээ.

2005 онд зам, гүүрийн засвар, арчлалтын ажилд олгохоор төсөвлөсөн 6,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна.

ЗТАЖЯ-ны том барилгын санхүүжилтийг объект бүрээр тулгаж үзэхэд 2004 оны үлдэгдэл санхүүжилтийг олгож, барьцаа хөрөнгө, захиалагчийн хяналтын зардал авч үлдсэн боловч 2004, 2005 оны эцэст байгаа гүйцэтгэгчдийн өглөг, авлагыг актаар баталгаажуулаагүй, гүйцэтгэгчдийн барьцаа хөрөнгийг тусад нь дансанд бүртгэж дүнг баталгаажуулаагүй байна. Тухайлбал,

- “УБ АЗЗАН” ХХК –ийн 2005 онд хийсэн авто замын засвар, арчлалтын ажлын гүйцэтгэлийг ЗТАЖЯ-тай тулган шалгахад 2,1 сая төгрөгөөр зөрүүтэй,
- Чойр- Замын Үүд чиглэлийн замын зураг төслийн санхүүжилтээс 10,9 сая, Өлгий- Цагааннуурын хатуу хучилттай замын санхүүжилтээс 23,2 сая төгрөгийг барьцаа болгон авч үлдсэн боловч гүйцэтгэгч нартай актаар баталгаажуулаагүй,
- Устынуул- Дуутын давааны хатуу хучилттай замын санхүүжилтээс 264,4 сая төгрөгийг гүйцэтгэгчид дутуу санхүүжүүлсэн,
- Чойр-Замын Үүд чиглэлийн хатуу хучилттай замын ажилд 1200,0 сая төгрөг төсөвлөсөн байхад Сангийн сайд, ЗТАЖС-ын 2005 оны 367/205 дугаар тушаалаар зохицуулалт хийн хасаж 2004 оны өглөгийн үлдэгдэл “МСРС” ХХК-д 242,2 сая төгрөг шилжүүлсэн байна.

ЗТАЖЯ тайлант оны эцэст хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 5,4 тэрбум төгрөгөөс хичнээн нь тухайн оны санхүүжилтээр гүйцэтгэгчдээ очих байсан, хичнээн нь барьцаа хөрөнгө болж үлдсэн нь тодорхойгүй, түүнд хяналт тавьж чадаагүй байна.



ЗТАЖС-ын 2005 оны 5 дугаар тушаалаар “Олон улсын болон улсын чанартай авто зам дээгүүр зорчин явж байгаа авто тээврийн хэрэгслээс төлбөр авах, захиран зарцуулах журам”-ыг баталсан байна.

ЗТАЖС-ын 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 13 дугаар тушаалаар Авто замын санд төвлөрсөн авто замын төлбөртэй цэгүүдийн хураамжийн 2004 оны орлогыг захиран зарцуулах төлөвлөгөөг баталжээ.

Дээрх төлөвлөгөөгөөр 2003,2004 оны төлбөрийн үлдэгдэл орлогоос 31,0 сая төгрөгөөр 8 ширхэг суурин холбооны станц, 9,4 сая төгрөгөөр 2 ширхэг явуулын холбооны станц,13,2 сая төгрөгөөр 4 ширхэг сансрын холбооны станц, 65,4 сая төгрөгөөр 4 автомашин, нийт 182,4 сая төгрөгийн зарцуулалт хийхээр зөвшөөрчээ.

Дээрх тушаалыг үндэслэн “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг зөрчин тендер зарлалгүй, зохих зөвшөөрөлгүйгээр дараахь үндсэн хөрөнгийг худалдан авчээ. Үүнд:

- ❖ 2005 оны 1 дүгээр сарын 27-нд 13,2 сая төгрөгийн 4 ширхэг Иридиум – Моторолла 9505 гар утас, сим картын хамт Сатмон ХХК –аас авсан бөгөөд түүнийг хэрэглэх эрх зүйн зөвшөөрөлгүйгээр ашиглаж байна.
- ❖ Монголын радио сонирхогчдын төвөөс 2005 оны 2 дугаар сарын 17-нд 40,2 сая төгрөгийн 8 ширхэг богино долгионы суурин станц , 2 ширхэг авто машины радио станц авч Төлбөрт үйлчилгээний цэг, ЗТАЖЯ-нд ашиглаж байна.
- ❖ 2005 оны 10 дугаар сарын 13-нд 15,8 сая төгрөгийн үнэтэй Тоёото Хайлюкс маркийн автомашин, тус бүр нь 15,5 сая төгрөгийн үнэтэй Митсубици Страда Пикап маркийн 2 ширхэг автомашин, 14,7 сая төгрөгийн үнэтэй Ниссан Датсон маркийн автомашин, нийт 4 ширхэг автомашиныг 61,5 сая

төгрөгөөр “Мандах хэт трейд” ХХК-аас Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлгүйгээр худалдан авчээ. Энэхүү мөнгөний шилжүүлгийг Сангийн яамны Төрийн сангийн газар хянаж чадаагүй байна. Учир нь төлбөрийн даалгаврын утганд “УБ-Мандалговь чиглэлийн хэсэгчилсэн хайрган хучилттай 275 км замын их засварын ажлын санхүүжилт” гэж худал бичсэн байна. Төрийн сангийн газарт уг шилжүүлгийг батлах холбогдох баримтгүй байна.

Эдгээрээс 3 автомашиныг Хоолт, Налайх-Тэрэлж, Цанын баазын Төлбөр хураах цэгийн менежерт хүлээлгэн өгсөн байна. Харин 1автомашин Рашаантын Төлбөр хураах цэгт очих ёстой байсан боловч аудитаар биет шалгалт хийхэд хаана, хэний зөвшөөрлөөр хэн эзэмшиж байгаа нь тодорхойгүй байлаа.

Авто машинуудыг Замын сангийн үндсэн хөрөнгөд орлого авсан боловч Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл аваагүйн улмаас ЗТАЖЯ-нд тээврийн хэрэгслийн гэрчилгээ албан ёсоор шилжиж ирээгүй, 3 автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь “Мандах хэт трейд” ХХК-ийн захирал Б.Эрдэнэбатын нэр дээр бүртгэлтэй байна.

Автомашины ашиглалтын байдалтай танилцахад эд анги нь хуучин дахин засах, солих шаардлагатай байна. Тухайлбал, Налайх-Тэрэлжийн Төлбөр хураах цэгт ашиглагдаж байгаа “Митсубици Страда Пикап” маркийн автомашинд одоогийн байдлаар 1,4 сая төгрөгийн сэлбэг, эд анги авах тооцоо гарсан байна. Гэрээнд “Мандах хэт трейд” ХХК баталгаат хугацаандаа хуучин эд анги сэлбэгийг өгөхөөр тусгасан боловч гэрээний зохих заалтыг биелүүлээгүй, тус компаний захирлыг олж уулзаж чадахгүй байна.

Иймд дээрх автомашинтай холбоотой үйл ажиллагааг холбогдох байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2005 онд Төлбөр хураах цэгийн 3 барилгыг авто замын төлбөрийн орлогоос санхүүжүүлэн барьж 2005 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан боловч чанарын шаардлага хангахгүй байна. Тухайлбал, Налайх-Тэрэлжийн чиглэлийн авто замын Төлбөр хураах цэгийн барилгын цонхны тавцан ховхорсон, хаалганы 8 ширхэг бариул эвдэрсэн, гадна талын хаалганы рам салсан, 128 метр хатуу хучилттай замыг эвдэлсэн гэх мэт эвдрэл гэмтэл гарсныг гүйцэтгэгч “Атар өргөө” ХХК засварлаагүй байна.

ЗТАЖЯ-ны 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 336/195 дугаар тушаалаар 2005 оны хөрөнгө оруулалт, замын санд тусгагдсан хөрөнгөөс авто замын салбарт 2005 онд хийгдсэн эрдэм шинжилгээ, стандарт, техникийн баримт бичиг боловсруулахад 203,0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 25 төсөл, арга хэмжээнд 202.2 сая төгрөг зарцуулсан байна.

Авто замын салбарын эрдэм шинжилгээ судалгаа, стандартчилалын чиглэлээр зохих хууль, журмын дагуу төлөвлөгөө хийж, аж ахуйн нэгжүүдтэй шууд гэрээ байгуулан судалгааны ажлыг бүрэн гүйцэтгүүлж, хүлээн авч хэрэгжүүлэх шатанд орсон байна.

Замын сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэлд дараахь зөвлөмж өгч байна.

- Замын сангийн харилцах дансны орлого, зарлагыг зүйл тус бүрээр тайлагнаж, барьцаа хөрөнгийг тусдаа дансанд байршуулах,
- Тайлант хугацааны эцэст үүссэн өглөг, авлагын үлдэгдлийг зохих журмын дагуу баталгаажуулж байх,
- Замын сангийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг бий болгон ажиллуулах,
- Замын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаа явдлыг таслан зогсоох,
- Төлбөр хураах цэгийн орлогын бүрдүүлэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, түүний удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох,

ЗТАЖЯ-ны Тээвэр үйлчилгээний төвийн бизнес төвийн /ТҮТБТ/ барилгын санхүүжилтийн талаар



Танилцуулга

Засгийн Газрын 2004 оын 10 дугаар сарын 8-ны өдрийн 202 дугаар тогтоолыг үндэслэн ЗТАЖСайдын 2004 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 10 дугаар тушаалаар Тээвэр үйлчилгээний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталснаар /хуучин нэрээр Авто тээврийн газар / байгуулагджээ. Тээвэр үйлчилгээний төв ЗТАЖЯ-наас авто тээврийг хөгжүүлэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болсон байна.

Тээвэр үйлчилгээний төв дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор авто тээврийн зохицуулалт, авто тээврийн хэрэгслийн техник, технологийн хяналт, тооллого, оношлогооны үйлчилгээ эрхэлж, орон нутагт эдгээр ажлыг өөрийн салбар нэгжүүд болон бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2005 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 42 дугаар тушаалаар тендерийн хороо байгуулан Тээвэр үйлчилгээний төвийн барилгыг авто тээврийн 80 жилийн ойноос өмнө ашиглалтад оруулахаар барилгын ажлыг барилгын буулгалт, өргөтгөл, барилгын засвар шинэчлэлт, барилгын инженерийн шугам сүлжээ гэж 3 хувааж тендер зарлахаар шийдвэрлэжээ.

Барилгын буулгалт өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчээр “ЦБА Ачлал” ХХК, барилгын засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр “Бөртэ Трейд” ХХК, барилгын инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “ДИ ЭНД ЭН” ХХК

тус тус шалгарч, барилгын ажлыг нийт 418,0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Барилгын ажлын санхүүжилтийн талаар

Барилгын зураг төсвийг “ААРЧ” ХХК-аар гүйцэтгүүлж 9,1 сая төгрөг төлжээ. Тээвэр үйлчилгээний төвийн Бизнес төвийн барилгын ажлын хөрөнгийг Иргэний нисэхийн ерөнхий газар, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам санхүүжүүлжээ. Үүнд:

- ❖ Иргэний нисэхийн ерөнхий газраас 2005 оны 6 дугаар сарын 28-нд 144,7 сая, 2005 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 150,0 сая, бүгд 294, 7 сая төгрөг,
- ❖ УБТЗ-аас 2005 оны 10 дугаар сарын 11-ны өдөр 75,0 сая, 2006 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр 74,6 сая, нийт 149,6 сая төгрөг тус тус ТҮТ-ийн дансанд төвлөрүүлжээ.

Барилгын ажлын гүйцэтгэлийн талаар

Барилгын буулгалт, өргөтгөлийн ажилд “ЦБА Ачлал” ХХК-д 134,3 сая төгрөг шилжүүлж, гэрээний үнээс 4,8 сая төгрөгийг барилгын ажлыг хугацаанд нь ашиглалтад оруулаагүйн торгууль суутгасан байна..

“Бөртэ трейд” ХХК-д 20,0 сая төгрөг шилжүүлсэн боловч ажлаа дуусгалгүйгээр орхисноос “Бөртэ трейд” ХХК-ний төлөх 12,5 сая төгрөгийн торгуулийг “ААРЧ ” ХХК-д төлөх нөхцөлтэйгөөр гэрээ байгуулан санхүүжилтийг үргэлжлүүлэн 131,4 сая төгрөг шилжүүлж, гэрээний үнээс 12,5 сая төгрөгийн торгуулийг суутган тооцсон байна.

“ДИ ЭНД ЭН” ХХК-д барилгын инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлд 135,9 сая төгрөг шилжүүлсэн байна. Дулааны шугамын хуучин байсан үзелийг солих шаардлагатай болсноос ажлын хөлсөнд 0,9 сая төгрөгийг “ДЭ ЭНД ЭН” ХХК-д нэмж төлсөн боловч тендерийн ажлын техникийн үзүүлэлтийн жагсаалтыг шинэчлээгүй байна.

Захиалагчийн зүгээс барилгын ажлын явц чанарыг хянах зорилгоор 1 барилгын инженерийг 7 сарын хугацаанд 2,1 сая төгрөгөөр цалинжуулсан байна.

Барилгын гүйцэтгэгч компаниудад ажлын хөлсөнд нийтдээ 402,5 сая, зураг төсвийн үнэнд 9,1 сая, захиалагчийн хяналтын зардалд 2,1 сая, бүгд 413,7 сая төгрөг шилжүүлжээ.

Анх барилгад хийгдсэн санхүүжилтийн үлдэгдэл 30,6 сая төгрөгөөс тендер зарлалгүйгээр Тээвэр үйлчилгээний төвийн барилгын гол хаалга, 3 дугаар давхрын хаалгыг шинэчлэхэд 15,9 сая, пасадыг засварлаж будахад 12,0 сая, урсгал зардалд 2,7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Дээрх барилгыг барилгын хуучин өртөг 132,0 сая төгрөгний өртөг дээр шинээр гарсан 413,7 сая төгрөгийн зардлыг нэмж Тээвэр үйлчилгээний төвийн хөрөнгийн дансанд бүгд 545,7 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Тээвэр үйлчилгээний төвийн бизнес төвийн барилгын ашиглалтын байдал

Тээвэр үйлчилгээний төвийн нэгдүгээр давхарт

- ❖ УБТЗ-ын билетийн кассад 80 м2 талбайг 2014 оны 7 дугаар сар хүртэл түрээслүүлэхээр гэрээ байгуулж түрээсийн төлбөрийг УБТЗХНН-ээс хөрөнгө оруулалтаар өгсөн хөрөнгөнөөс суутган тооцохоор гэрээнд заажээ.
- ❖ 202 м2 талбайг Гадаадын иргэний харъяатын асуудал эрхэлсэн албанд түрээслүүлэн сард 0,9 сая төгрөг авахаар гэрээ байгуулжээ.

Бусад талбайг аялал жуулчлалын “Нээлттэй сайхан монгол” ХХК-д сард 2,9 сая төгрөгөөр түрээслүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Л.ЖАВЗМАА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-64-06, Факс: 31-06-12
E-mail: info@mrtt.pmis.gov.mn; http://www.mrtt.pmis.gov.mn

2006.09.07 № 3/2529
танай _____-ны № _____-т

Гүйцэтгэлийн аудитын тайланд санал
хүргүүлэх тухай

Танай газраас манай сайдын багцын 2005 оны төсвийн хөрөнгийн зарцуулалтын байдалд гүйцэтгэлийн аудит хийсэн тайланг сайдад танилцуулж, судалж танилцлаа.

Аудит хийхэд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар гаргасан албан шаардлага, актыг судалж үзээд доорхи санал, тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Албан шаардлагын талаар

1.Монгол орныг гадаадад сурталчилах чиглэлээр хэвлүүлсэн 21.9 сая төгрөгийн танилцуулах хуудас, сэтгүүл, календарчилсан танилцуулгын орлого, зарлагын тайланг гаргаж тайлан балансад тусгалаа.

2.Хархорин хот байгуулагдсаны 785 жилийн ойн арга хэмжээний зардлын тайланд 1.727.210 төгрөгийн баримт дутуу байсныг аялал, жуулчлалын газраас баримтыг нөхөн гаргуулж бүрдүүлсэн.

3.Аялал, жуулчлалын сангаас худалдан авсан 34.15.446 төгрөгийн DVD, CD, танилцуулга хөтөчийн гарын авлагыг орлогод авч, тайлан балансад тусгалаа.

4.Олон улсын болон улсын чанартай авто замаар зорчсоны хураамжийн орлогоос худалдан авсан 13.2 сая төгрөгийн үнэтэй 3 ширхэг Иридиум-Моторолла 9505 маркийн гар утсыг сайд, төрийн нарийн бичгийн дарга, авто замын газрын дарга нар хөдөө орон нутагт ажиллах үеэр авто зам, гүүрийн барилгын байдлын талаар шуурхай мэдээлэл авах, мэдээлэл хүргэх, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулахад ашиглах зориулалтаар худалдан авч ашиглаж байгаа болно.

5.Олон улсын болон улсын чанартай авто замаар зорчсоны хураамжийн орлогоос худалдан авсан 61.5 сая төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг автомашиныг яамны данс, бүртгэлд тусгасан бөгөөд дээрх автомашиныг ашиглаж буй Авто замын хяналт, судалгааны төвд шилжүүлэхээр Төрийн өмчийн хороонд хандаад байна.

6.Замын сүлжээний засвар, арчлалтын зардалд батлагдсан 6.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн тайланг гаргаж төрийн сангийн газартай тооцоо нийлж, ахлах аудитор Л.Одгэрэлд хүргүүллээ.

08 1855

7.2005 оны жилийн эцсийн тайланд тусгагдсан 14.9 тэрбум төгрөгийн өглөг 56 байгууллагатай холбоотой бөгөөд 50 байгууллагатай тооцоо нийлж 4.2 тэрбум төгрөгийн өглөгийг барагдуулсан, 3.5 тэрбум төгрөгийн авлага 22 байгууллагатай холбоотой бөгөөд үүнээс 20 байгууллагатай тооцоог актаар баталгаажууллаа.

8.Харилцах дансны жилийн эцсийн үлдэгдэл 5.4 тэрбум төгрөг нь 56 байгууллагатай холбоотой бөгөөд үүнээс 50 байгууллагын 4.2 тэрбум төгрөгийг тооцоо нийлж шилжүүлсэн.

9.Жилийн эцсийн тайланд тусгагдсан норм, нормативын сангийн 57.6 сая төгрөгийг салбарын норм, норматив, стандарт шинээр боловсруулах ажилд зарцуулах шийдвэр гаргасан. Мянганы замын сангийн 120.4 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэл тайлан балансад тусгагдсан байсан бөгөөд энэ хөрөнгийг Мянганы замын үндэсний хорооны шийдвэрээр зарцуулдаг болно.

10.Зам, гүүрийн барилгын ажлын гүйцэтгэлээс авч үлдсэн баталгаат хугацааны барьцааны хөрөнгийн тооцоог гүйцэтгэгч байгууллага нэг бүртэй тооцоо нийлж баталгаажуулах ажил хийгдэж байна.

Хоёр. Тавигдсан актуудын талаар

1.Төр засгийн үйлчилгээ, аж ахуйн газраас нөхөн төлүүлж авах 360.0 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлсэн бөгөөд актанд дурдсан хугацаанд биелэх бүрэн боломжтой.

2.Яамны аппаратын ажиллагсадаас суутган тооцох 500.0 мянган төгрөгийг холбогдох хүмүүсийн цалингаас суутгаж актанд дурдсан хугацаанд барагдуулах бүрэн боломжтой.

3.Иргэний нисэхийн ерөнхий газраас актын дагуу 6.948.605 төгрөгийг аялал жуулчлалын санд төвлөрүүлсэн.

4.Монгол Улсын Ерөнхий сайд, манай сайдын ХБНГУ, Бельги, Нидерландын Вант Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр "ММ" агентлагаас сурвалжлага хийхээр дагалдан явсан сурвалжлагч Д.Батзаяагийн зардлын тайланд хавсаргасан зочид буудлын баримт Д.Гомбо /хамт явсан оператор/-ын нэр бичигдсэн учир уг актыг баримт нөхөн бүрдүүлэх албан шаардлага болгон өөрчилж өгөхийг хүсье.

Аудитын тайланд тусгагдсан бусад асуудлын талаар санал нэгтэй байгаа бөгөөд зөрчил дутагдлыг арилгах талаар тодорхой арга хэмжээ зохиож тайлагнах болно.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Ц.БАТ-ЭНХ